



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ-ын 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/10/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059.
Утас: 7037-3089, Факс: (978) 7037-3089
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 94

таныг _____-ны № _____-т

**“ДАРХАН ХОТЫН ХОГ ТЭЭВЭР”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Л.ОТГОНБАЯР
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар өөрчлөлтгүй санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэл тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 2,964,282.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлого 97,027.9 мянган төгрөг буюу нийт 3,061,309.9 мянган төгрөгийн орлого төлөвлөснөөс 3,061,309.9 мянган төгрөгийн орлого олж, 3,731,090.1 мянган төгрөгийг зарцуулж 669,780.2 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахад 747,816.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал шууд нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2025 оны 05 дугаар тогтоолоор 60,000.0 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл, 330,000.0 мянган төгрөгийн аюултай хог хаягдал устгах үйлдвэрийн барилга, аюултай хог хаягдал шатаах зуух, мөн 21 дүгээр тогтоолоор 187,450.0

4526050299

мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл, мөн оны аймгийн Засаг даргын 01-А/143 захирамжаар хог хаягдлын менежмент төслийн байр, талбай, гэрэлтүүлэг, орон нутгийн өмчийн газрын А/36 дугаар тушаалаар 13,766.6 төгрөгийн тавилга, эд хогшил, тусгай зориулалтын ДЭУ-Улит галын машины мотор үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 95 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	149,698,852.83	98,820,797.76
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	212,975,259.10	312,234,334.25
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	362,674,111.93	411,055,132.01
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,091,708,782.60	4,965,513,043.19
1.2.2	Биет бус хөрөнгө	1,262,723,869.32	1,262,723,869.32
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	1,477,299.97
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,354,432,651.92	6,229,714,212.48
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,717,106,763.85	6,640,769,344.49
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,613,465.00	472,175.00
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,613,465.00	472,175.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,613,465.00	472,175.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	-	-
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,781,027,010.43	7,376,611,056.83
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(66,533,711.58)	(736,313,887.34)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,714,493,298.85	6,640,297,169.49
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,717,106,763.85	6,640,769,344.49

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,281,299,000.00	2,964,282,000.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	1,281,299,000.00	2,964,282,000.00
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	24,130,100.00	97,027,991.58
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,371,962,811.58	3,723,979,250.28
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		7,110,917.06
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(66,533,711.58)	(669,780,175.76)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(66,533,711.58)	(669,780,175.76)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(66,533,711.58)	(669,780,175.76)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
26	Бусад олз (гарз)		
27	Орлогын нийт дүн		-
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл			5,781,027,010.43	-	5,781,027,010.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл		-	5,781,027,010.43	-	5,781,027,010.43
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(66,533,711.58)	(66,533,711.58)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл		-	5,781,027,010.43	(66,533,711.58)	5,714,493,298.85
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	-	-	5,781,027,010.43	(66,533,711.58)	5,714,493,298.85
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-		(669,780,175.76)	(669,780,175.76)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-		1,595,584,046.40		1,595,584,046.40
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2025 оны 12 -р сары 31-ний үлдэгдэл	-	-	7,376,611,056.83	(736,313,887.34)	6,640,297,169.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,026,527,706.30	4,954,260,773.58
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	721,098,606.30	1,935,525,782.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	1,281,299,000.00	2,964,282,000.00
	Бусад мөнгөн орлого	24,130,100.00	54,452,991.58
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,836,873,718.47	4,970,513,618.65
	Ажиллагчдад төлсөн	641,285,497.60	1,436,305,575.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	78,143,458.05	444,260,268.52
	Бараа материал худалдан авахад төлсөн		
	Ашиглалтын зардалд төлсөн	1,200,000.00	45,217,842.50
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	244,088,401.60	498,698,650.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	1,637,583.00	2,080,959.00
	Даатгалын төлбөрт төлсөн	10,549,645.00	3,008,610.00
	Бусад мөнгөн зарлага	859,969,133.22	2,540,941,713.63
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	189,653,987.83	(16,252,845.07)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(39,955,135.00)	(34,625,210.00)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	39,955,135.00	34,625,210.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		

	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(39,955,135.00)	(34,625,210.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	149,698,852.83	(50,878,055.07)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		149,698,852.83
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,698,852.83	98,820,797.76

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
Нийт орлого	м/төг	1,305,429,100.00	2,964,282,000.00	3,061,309,991.58	97,027,991.58	96.83
Үүнээс: Орон нутгийн төсвөөс	м/төг	1,281,299,000.00	2,964,282,000.00	2,964,282,000.00	-	100.00
Үйл ажиллагааны орлого		24,130,100.00	-	97,027,991.58	97,027,991.58	-
Нийт зардал	м/төг	1,371,962,811.58	2,964,282,000.00	3,731,090,167.34	766,808,167.34	79.45
Үүнээс:						
а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг					
б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	1,371,962,811.58	2,964,282,000.00	3,731,090,167.34	766,808,167.34	79.45
в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг				-	-
Цэвэр ашиг, алдагдал	м/төг	(66,533,711.58)	-	(669,780,175.76)	(669,780,175.76)	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 657,664.9 мянган төгрөгийн алдаа¹ нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 18.1, НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, НББОУС-7 “Мөнгөн гүйлгээний тайлан”, СТОУС 7 “Санхүүгийн хэрэглүүр, тодруулга”-т заасантай тус тус нийцээгүй тулд аудитын явцад дараах байдлаар залруулав. Үүнд:

- Тус газар нь 2025 оны хагас жилийн санхүүгийн орлогын тайланд хог хураамжийн төлбөрийг 426,015.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг нэмж бүртгэн залруулав.
- Тус байгууллага нь ажилчид олгосон 15,200.0 мянган төгрөгийн өвлийн болон зуны хувцсыг зарцуулахгүйгээр бараа материалын тайланд тайлагнасан байсныг үйл ажиллагааны зардлаар бүртгэж залруулав.
- Татварын цахим тайлангийн системд цалин болон түүнтэй адилтгах орлогыг тайланд оны Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 12,207.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг нэмж залруулав.
- Тайлант онд мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгөн зарлагыг 204,242.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг нэмж залруулав.

Мөн аудитаар нийт 4,500.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 1 зөвлөмж хүргүүлээ.

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

5.1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын мөнгөн хөрөнгийг зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад 4,500.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарлагын гүйлгээ хийж, санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “*Үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланг бэлтгэж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус Дархан хотын хог тээвэр нь 2025 оны хагас жилийн санхүүгийн орлогын тайланд хог хураамжийн төлбөрийг 426,015.4 мянган төгрөгийг дутуу тайлагнасан байна.	1	426,015.4	1	426,015.4			1	426,015.4	-	-	-	-
Тус байгууллага нь ажилчид олгосон 15,200.0 мянган төгрөгийн өвлийн болон зуны хувцсыг зарцуулахгүйгээр бараа материалын тайланд тайлагнасан байна.	1	15,200.0			1	15,200.0	1	15,200.0				
Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын дүн нь цахим татварын тайлангийн ХХОАТ-тай 12,207.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	12,207.2			1	12,207.2	1	12,207.2				
Тайлант онд мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын байгууллагад төлсөн дүнг 204,242.3 мянган төгрөгөөр буруу тайлагнасан байна.	1	204,242.3			1	204,242.3	1	204,242.3				
Дүн	4	657,664.9	1	426,015.4	3	231,649.5	4	657,664.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллагын мөнгөн хөрөнгийг зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	4,500.0	-	-	-	-	1	4,500.0	-	-	-	-
Дүн	1	4,500.0					1	4,500.0		-	-	-